



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар A/61

Арвайхээр

**Газар эзэмших эрх шинээр олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар баг Ренчинпилжээгийн гудамж 139 тоотод байрлах "Онги ус суваг" ОНӨААТҮГазарт 1845м<sup>2</sup> газрыг албан конторын зориулалтаар, МСҮТөвийн урд 31м<sup>2</sup> гүний усны худгийн доорх газрыг МСҮТөвд ус түгээх цэгийн зориулалтаар 40 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100146